**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2022 оны 01 сарын 21 өдөр Дугаар А/04 Дуурсах

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын А/559 дугаар тушаалын 2 дугаар зорилтын 2.2 дах заалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ковид-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Дурсамж лед дэлгэц” аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, видео шторк, гарын авлага, зөвлөмж, цаг үеийн мэдээ, мэдээллийг түгээн ажиллахыг эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Амарсайнуу)-д үүрэг болгосугай.

2. Үйл ажиллагаанд зарцуулах 1.200.000 (Нэг сая хоёр зуун мянган) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг Ахлан нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга (Д.Балжмаа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭНХЖАРГАЛ

D:/2022/2022 tushaal.docx

642101135